

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 17/457

ШУС, НУС

2016

“ДООД ХЭРГИЙН ЯАМ” ХҮРТЭЛ ДООШОО ОРСОН ТЕЛЕВИЗҮҮД

Л.Норовсүрэн*, Уяхан**

* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхмийн профессор, шинжлэх ухааны доктор (Sc.D.)

** МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхмийн магистрант

Түлхүүр үг: мэдээлэл, телевизүүд, зах зээл, өрсөлдөөн, мэдлэг, эх сурвалж, агуулга, алдаа, баримт, эрэн сурвалжлах, ярианы хэл, бичгийн хэл, хөтөлбөр

Улс орон чөлөөт зах зээлд шилжиж, хэвлэл мэдээллийн эрх чөлөө бодитой болсон нь ардчиллын үнэт зүйлсийн нэг мөн. Гэвч энэ боломжийг зөв бөгөөд үр нөлөөтэй ашиглах явдал салбар бүрт хангалтгүй байгааг олон нийт шүүмжлэн хэлэлцдэг. Ийм шүүмжлэлийн нэг бай нь Монголын телевизүүд. Юуны өмнө телевизийн талаар судлаачид хийгээд үзэгчдийн байр суурь харилцан адилгүй байдгийг хэлэх нь зөв байх. Зах зээлийнхээ жам ёсоор бол аль болох олон телевизтэй байх тутам өрсөлдөөн буй болж, нэг талаар мэдээллийн чанар сайжирч, нөгөө талаар өөр өөр өнгө аяс, чиглэлтэй телевизүүд гарч ирнэ гэж үздэг.

Гэтэл Монгол шиг цөөн хүн амтай, жижигхэн зах зээлтэй оронд дээр дурдсан жам ёс эерэг бус, харин сөрөг

үр дагавар авчирч байна. Тухайлбал телевизүүд нэг үйл явдлын мэдээг хэвэнд шахсан мэт адилхан үзүүлдэг, олж авсан мэдээллээ олон хоногоор давтдан гаргадаг, ач холбогдол багатай элдэв зүйлээр эфирийн цагийг бөглөдөг зэрэг нь мэдээллийн эх сурвалж хомс байдагтай холбоотой гэж үзэх хүмүүс ч байдаг. Монголын телевизүүдээр ёс юм шиг өдөр бүр гарч байдаг хоёр зуу орчим хүн байдаг гэсэн үг гарсан нь мөнөөх л мэдээллийн зах зээл цомхонтой холбоотой гэж тэд үздэг.

Монголд телевиз нь олон, түүгээр үзүүлж харуулах үйл явдал нь хязгаартай учраас телевизүүд шүүмжлэлийн бай болдог, эсэх нь тусдаа асуудал бөгөөд би энэ тухай өгүүлэхийг хүссэнгүй. Зөвхөн гаргаж байгаа мэдээллийн ур чадвар, үр нөлөөний тухай ярих гэсэн юм. “Мэдээллийн” гэдэг үгийг онцлоод байгааг минь та анзаарч байгаа байх. Телевиз анх дүрсжүүлсэн мэдээлэл түгээх зорилгоор үүссэн, тэр ч чанараараа өнөөдрийг хүртэл “мэдээллийн

хэрэгсэл” гэдэг нэрээ хадгалсаар байгаа билээ. Харин сүүлийн үед “телевизийн урлаг” гэдэг үг нэлээд дэлгэрэх болов. Энэ нь юуг ч илэрхийлж чадах дүрслэх хэрэглүүрийнх нь өргөн боломжийг үнэлсэн үг болохоос биш, түүнийг айл бүрийн хойморт байдаг “гэрийн театр” болгох гэсэн хэрэг хараахан биш байх. Мэргэжлийн үүднээс авч үзвэл телевизээс нийгэмд хэрэгтэй, шинэ сэргэг мэдээлэл түгээж, нийгмийн гишүүдийг харилцуулж байдаг тэр хэсэг нь сэтгүүл зүйд илүү хамаатай юм. Тиймээс ч би энд телевизүүдийн зөвхөн мэдээллийн нэвтрүүлгийн тухай ярих болно.

Телевиз манай орны мэдээллийн систем дэх хүчирхэг хэрэгсэл гэдэгтэй хэн ч маргахгүй. Тэрхүү хүчирхэг хэрэгслийн боломжийг хэрхэн ашиглах нь түүнийг хөдөлгөж байгаа сэтгүүлч, уран бүтээлчдийн мэдлэг, ур чадвараас шууд шалтгаалж байгааг юуны өмнө тэмдэглэе. Шуудхан хэлэхэд телевизийн мэдээллийн хөтөлбөрүүд шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна. Эхлээд МҮОНТ-ийн “Монголын мэдээ” сувгийн мэдээллийн хөтөлбөрийг авч үзье. Тус сувгийн зонхилох мэдээлэл “Цагийн хүрд” нэвтрүүлгээр өдөр бүр гардгийн дээр өдөрт хэд хэдэн удаа цацдаг “Мэдээ”, “Цаг үе, үзэл бодол”, “Нээлттэй хэлэлцүүлэг” зэргийг нэрлэж болно. Эдгээр нэвтрүүлэгт сэтгүүлчийн ур чадвар, төрөлх хэлний мэдлэг, хариуцлага дутагдаж байгааг захаас аван харж болохоор байдаг.

Нэгдүгээрт: сэтгүүлчдийн улс төр, эдийн засгийн мэдлэг хангалтгүй байгаагаас эх сурвалжаас юмны цаад учир шалтгааныг тодруулж чаддаггүй,

өөрөөр хэлбэл зочиндоо хөтлөгддөг дутагдал түгээмэл ажиглагддаг. “Монголын мэдээ” сувгийн 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Цагийн хүрд” нэвтрүүлгээр сэтгүүлч Отгонтуяа зочин Бямбасайхантай ярилцахдаа “Оюу толгойн далд уурхайг ашиглаж эхэлснээр ард түмэнд яг юу ирэх вэ?” гэсэн боломжийн асуулт тавихад зочин ярилцагч хариулахаас илт зайлсхийж “Сайн хийгдсэн төсөл учраас гадаадынхан зээл өгч байна” гэж тэс ондоо юм ярихад сэтгүүлч асуултандаа нэхэл хатуу байж чадсангүй толгой дохиод сууж байв. Уг нь ярилцлага гэдэг бол олон нийтийн анхаарал татсан учир битүүлэг, ээдрээтэй асуудлыг сонгож аваад уг асуудлыг сайн мэдэх эх сурвалжаас үнэнийг олж мэдэх нэг янзын урлаг юм. Ингэхийн тулд эх сурвалжаас юу мэдэж авахаа урьдчилан төлөвлөсөн байх учиртай.

УИХ-аас 2015 оны эцсээр баталсан “Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хууль”-ийг арилжааны олон телевиз эсэргүүцэж тухайн цагт нь мэдээлж байхад МҮОНТ чимээ ч үгүй өнгөрсөн нь ард иргэдэд халтай тэр хуулийг талархаж байгаагаас өөрцгүй мэт сэтгэгдэл төрүүлж байв. Уг хуулиар бол банк иргэний 50 саяын үнэтэй газрыг барьцаанд аваад таван сая төгрөгийн зээл олгох, хэрэв иргэн зээлээ төлж чадахгүй бол таван сая төгрөг төлж чадаагүйнх нь төлөө 50 сая төгрөгийг нь үл маргах журмаар хурааж авах юм байна. Ийм харгис хууль баталчихсаныг Үндсэн хуулийн цэц буруутгаад байхад олон нийтийн эрх ашгийг хамгаалах учиртай толгой телевиз хамгийн түрүүнд дуугарах учиртай баймаар. Агуулгын алдаатай,

заримдаа хэтэрхий гэнэн ч гэмээр мэдээлэл байнга шахам гарч байна. “Цагийн хүрд” нэвтрүүлгийн 2015 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн мэдээг уншсан нэвтрүүлэгч “Энэ жил манай орны ихэнх нутгаар өвөлжилт хүндрэх төлөвтэй байна. Ийм учраас манай сурвалжлагч Дундговь аймагт ажиллаад ирлээ” гэв. Дундговь аймагт сэтгүүлч очихоор өвөл сайхан болчих юм шиг инээдтэй санаа гарч байгааг эрхэм “уран бүтээлчид” анзаарах мэдлэг, мэдрэмж үгүй бололтой.

УИХ-ын 2016 оны нэгдүгээр сарын 22-ны өдрийн хуралдаан дээр болсон Ш.Сайханбилэг, Г.Уянга хоёрын хэрүүлийг арилжааны телевизүүд тэнцвэртэй үзүүлж байхад “Цагийн хүрд” зөвхөн Г.Уянгыг мохоосон Ш.Сайханбилэгийн үгийг дамжуулаад өнгөрөв. Мэдээллийн тэнцвэртэй байдал биш, эрх баригчдыг зулгуудаж сөрөг хүчнийг намнах нь эрхэм сэтгүүлчид ашигтай байсан бололтой. 2012 оноос хойш эрх баригчдыг ямар ч аргаар хамаагүй магтаж, хамгаалах сэтгэлгээ МҮОНТ-д амь бөхтэй орших болсныг мэргэжлийн хүрээнийхэн төдийгүй үзэгчид ч шүүмжлэх болсон. Ийм олон үйлдлийн нэг жишээ нь 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Цагийн хүрд” нэвтрүүлгээр сэтгүүлч Отгонтуяа “Аймгуудад 1000 айлын орон сууц барих зорилт үндсэндээ биелжээ” гэж хэнэг ч үгүй мэдээлж байсан явдал. Тийнхүү мэдээлснээс хойш бүтэн найман сарын дараа төв болон баруун зүгийн хэд хэдэн аймгийн төвөөр дайрч өнгөрөхөд бараг хуучин янзаараа байж байх жишээтэй.

Баримтыг зөрүүтэй мэдээлэх нь телевизүүдийн гэм биш зан болсон.

2015 оны сүүлчээр далд уурхайн бүтээн байгуулалтад зээл олгосон дэлхийн банкуудын тоог нэг телевиз 15 гэж байхад нөгөөх нь 20 хэмээн мэдээлж байлаа. “Монголын мэдээ” сувгийн 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Цагийн хүрд”-ээр 2015 оны жилийн эцсийн малын тоог сэтгүүлч 55 сая 957 мянга гэж мэдээлж байхад түүнтэй зэрэгцээд Үндэсний статистикийн хорооны газрын дарга 58 сая 958 мянга гэж байв. Үзэгчид хэн нь зөв, хэн нь буруу хэлж байгааг мэдэх аргагүй. Телевизийн бодлого тодорхойлогчдод улс орон хийгээд дэлхий дахинд болж байгаа үйл явдлыг тэгш харж, ач холбогдол, хор хохирлыг зөв үнэлэх чадвар дутагдаж байгаа нь илэрхий харагддаг. Өөр үгээр хэлбэл үйл явдалд авах гээхийн ухаанаар хандаж чаддаггүй. Захын жишээг хэлье. 2015 оны эцсээр Нийслэлийн нэгдүгээр амаржих газарт эмч, сувилагчдын хариуцлагагүйгээс эх, хүүхэд эндэх явдал удаа дараа гарч байгааг мэдээллийн бусад хэрэгслүүд хурцаар шүүмжилж байхад МҮОНТ ёс төдий мэдээлээд өнгөрөв.

Зүй нь үндэсний эрх ашгийг дээдлэх үүрэгтэй энэ телевиз ийм хариуцлагагүй явдлын уг үндсийг эрэн сурвалжлах хэмжээнд судалж удирдах түвшний хүмүүст дохио санамж болохуйц даацтай нэвтрүүлэг бэлтгэх ёстой баймаар сан. Иргэд, олон нийт рүү хандсан нийтлэлийн бодлого дутагдаж байгаагийн баримт энэ юм.

МҮОНТ-ээр баримтгүй, эзэн холбогдогчгүй, зөрчилтэй мэдээлэл цөөнгүй гардаг. 2015 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн “Цагийн хүрд” нэвтрүүлгээр

нийгмийг хүчирхийлэлд уриалахын хор холбогдлын тухай мэдээлэл цацагдав. Эрдэнэбулганы бэлтгэсэн энэ материалд Х.Наранжаргал нарын хэд хэдэн хүн үзэл бодлоо илэрхийлж арав шахам минут ярьсан боловч хэн, юуны учир, хэнийг хүчирхийлэлд уриалсан тухай нэг ч баримтыг дурдсангүй. Тэгэхээр хүчирхийлэлд уриалсан явдал гараагүй, болоогүй буюу байхгүй юмны тухай хоосон үг ярьсан болж таарч байна. Үүнээс гурван хоногийн дараах “Цагийн хүрд”-ээр “Хамтын тэтгэврийн тухай хууль”-ийг хэлэлцэх асуудлаар МАН-ын бүлэг завсарлага авсан, Нийгмийн бодлого, боловсрол, шинжлэх ухааны байнгын хороо хэлэлцэж нэгдсэн хуралдаанд оруулсан хоёрын алин болох нь тодорхойгүй зүйл ярив.

“Цагийн хүрд”-ээр заримдаа мэдээллийн бус, асуудал хөндсөн, эсвэл соён гэгээрүүлэх шинжтэй зүйл гардаг нь цаг үеийн шинэ сэргэг мэдээлэл дутсантай холбоотой байдаг шиг санагддаг. 2015 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн “Цагийн хүрд”-ээр сэтгүүлч Т.Эрдэнэчимэг түрээсийн орлогын ач холбогдлын тухай баахан ярив. Гадаадын орнууд түрээсээс хэрхэн орлого бүрдүүлдэг тухай олон жишээ баримт дурдсаны дотор Хонг Конг төсвийн орлогынхоо 35 хувийг зөвхөн түрээсээс олдог тухай ч өгүүлэв. Энэ бол мэдээ, сурвалжлага гэхээсээ илүү бие даасан нэвтрүүлэг баймаар зүйл байлаа. “Монголын мэдээ” суваг 2015 оны 12 дугаар сарын 18-ны 18:00 цагийн мэдээний эцэст “12 дугаар сарын 17 буюу өнөөдрийн валютын ханшийг танилцуулъя” гэж ярьснаас үзвэл валютын ханшийн мэдээгээ өдөр өдөрт

нь солилгүй улируулан уншдаг бололтой юм.

Улс төрийн аль нэг нам, хүчинд илэрхий үйлчлэх, мэдээллийн тэнцвэрт байдлыг алдагдуулах, үйл явдал, үзэгдлийг улс төрийн болон хувийн эрх ашгийн үүднээс тайлбарлах зэрэг нь үндэсний хэмжээний мэдээллийн хэрэгсэлд хориотой зүйл юм. Гэтэл МҮОНТ 2012-2016 оны сонгуулийн хооронд Ардчилсан намын телевиз шиг ажиллаж ирсэн нь хэн бүхэнд тодорхой байсан. Энэ гаж зуршил нь 2016 оны сонгуулийн өмнө улам гаарч эрх баригч хүчний удирдагчдын сонгуулийн шоу-г өдөр дараалан дамжуулж байсныг үзэгчид мартаагүй. Тус телевиз 2016 оны 6 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд Ардчилсан намын дарга З.Энхболд, Ерөнхий сайд Ч.Сайханбилэг нарт эфирийнхээ зайг харамгүй нээж, Ардчилсан нам улс орноо өрөнд унагаагүй, шинэчлэлийн болон шийдлийн засгийн газрууд Монгол улсын 70 жилд хийж чадаагүй ажлыг дөрвөн жилд хийсэн, “Эрдэнэт”-ийн 49 хувийг монголчууд авсан гэх мэт үнэнд нийцэхгүй мэдээллээр ард түмний тархийг угаах боломж олгож байсан нь ёс зүйгүй хэрэг юм.

Телевизээр учир зүйн алдаатай үг, өгүүлбэр байнга сонсогдож, үзэгдэж байдаг. Ийм алдаа мэргэжлийн өндөр түвшинд ажиллах ёстой Үндэсний олон нийтийн болон Арилжааны телевизүүдийн аль алинд түгээмэл байна. “Монголын мэдээ” сувгийн 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн “Цагийн хүрд”-д “БНСУ манай улс дах хөрөнгө оруулалтынхаа хэмжээгээр эхний 5 дугаар байранд ордог” гэсэн урсдаг мэдээ харагдаад өнгөрч байх юм. Энэ

өгүүлбэрт найруулгын болон зөв бичгийн хэд хэдэн алдаа байна. Бичгийн болон ярианы хэл гагцхүү үйл үгээр амилж утга санаа илэрхийлдгийг мэдэхгүй хүн ховор байх. Гэтэл ярьж, бичихийн аль алинд үйл үгийг устгах, тэгснээрээ төрөлх хэлээ мөхөөхийн цондон болсон “хөрөнгө оруулалт”, “ургац хураалт”, “хүлээн авалт” гэх мэт үг хэрэглэх зуршлаас телевизүүд салж чадахгүй байна. Зүй нь “БНСУ манай улсад оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр” гэвэл зөв болох байж. Алдаа үүгээр дууссангүй. 5 дугаар байр бол эхнийх биш, тав дахь нь юм. “Эхний” гэдэг үгийг заавал хэрэглэх гээд байгаа бол “эхнээсээ 5 дугаарт” гэвэл зөв болно. Хөрөнгө оруулах нь уралдаан тэмцээн биш учраас “байранд” гэдэг үг бараг илүүц юм. Эцэст нь “дахь” гэхийг “дах” болгосон нь бас л бүдүүлэг алдаа болсон байна. Дүгнээд үзвэл 11 үгтэй өгүүлбэрт наад зах нь дөрвөн алдаа гаргасныг хэвийн гэж үзэх үндэсгүй юм.

“Монголын мэдээ” сувгийн мэдээнд “Хэнтий аймгийн Батноров суманд мал хээлтүүлэг зуун хувь хээлтэв” (“Цагийн хүрд”. 2016.03.11), “Ноён Пан Ги Мун өөрийн зүгээс хэлсэн үгэндээ” (“Цагийн хүрд”. 2016.07.09), “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх аян” (“Цагийн хүрд”. 2016.09.27), “Монгол улс, Словени улсын ерөнхий сайдтай

уулзав” (ММ суваг. 18:00 цагийн мэдээ. 2016.07.15), “Шүлхийгээр өвчилсөн үхрийг устгалд оруулжээ” (2016.08.29), “Усанд осолдож амь насаа алдсан иргэдийн тоо өсчээ” (Мөн тэнд), “15 нас хүртлэх хөлбөмбөгийн улсын аварга шалгаруулах тэмцээн” (“Цагийн хүрд”. 2016.02.23), “Зөөврийн авто машинаар ус татаж байна” (мөн тэнд) гэх мэт алдаатай өгүүлбэр бараг нэвтрүүлэг бүхэнд тохиолддог.

«

МҮОНТ үндэсний хэмжээний том телевизийн хувьд улс орны амьдралыг бүхэлд нь харж, нийгмийн ач холбогдол бүхий онцгой чухал асуудалд анхаарлаа түлхүү хандуулж, шуурхай тусгах учиртай билээ. Гэтэл энэ оосор бүчгүй орчлонгийн хаанаас нь олов гэмээр дэндүү жиижигхэн, хэнд ч хэрэггүй юмаар эфирийн цагаа нөхцөөж байх нь зохимжгүй, бас хариуцлагагүй хэрэг

»

хэрэггүй юмаар эфирийн цагаа нөхцөөж байх нь зохимжгүй, бас хариуцлагагүй хэрэг. Тус телевизийн эфирээр “Бельгид ахуйн ослоор нэг хүн нас барав” (Бичмэл мэдээ. 2016.08.27), “Румынд үерийн улмаас хоёр хүн нас барав” (“Цагийн хүрд”. 2016.06.04), “Хөвсгөл аймгийн дунд сургууль номын сантай болов” (“Цагийн хүрд”. 2016.06.06) гэх мэт мэдээнүүд цөөн бус тоогоор цацагдаж байгаагаас дээрх дүгнэлтийг хийж байна. Ийм мэдээ бэлтгэж байгаа хүмүүс хэрэв манай улсад ахуйн ослоор нэг биш, тав

МҮОНТ үндэсний хэмжээний том телевизийн хувьд улс орны амьдралыг бүхэлд нь харж, нийгмийн ач холбогдол бүхий онцгой чухал асуудалд анхаарлаа түлхүү хандуулж, шуурхай тусгах учиртай билээ. Гэтэл энэ оосор бүчгүй орчлонгийн хаанаас нь олов гэмээр дэндүү жиижигхэн, хэнд ч

зургаан хүн нас барчихлаа гэхэд гадаадын телевизүүд чухал гэж үзэн хөтөлбөртөө багтаах уу гэж бодох учиртай.

“Монголын мэдээ” сувгийн цаг уурын бичгэн мэдээ, нэвтрүүлэгчийн үг байнга зөрдөг, валютын хийгээд барааны үнэ ханшийн мэдээ нь хуучирсан байдаг, үйл явдлын мэдээнд цаг үетэйгээ үл зохилдох дүрс ашигладаг гээд олон дутагдлыг тоочиж болно. Жишээ нь сурагчдын зуны амралтын тухай ярьж байхад “Найрамдал” зуслан цасанд дарагдсан үеийн дүрс үзүүлсэн (“Цагийн хүрд”. 2015.06.15), сэтгүүлч Бямбацэцэгийн хөтөлсөн “Нээлттэй хэлэлцүүлэг” (2016.08.26), хүүхдийг цахим тоглоомд донтохоос сэргийлэх тухай эмчийн зөвлөгөө (“Цагийн хүрд”. 2015.12.23) зэрэгт дуугүй дүрс удтал үргэлжилсэн, тоймч Алтангэрэл “Долоо хоног” тоймд Г.Мэнд-Ооёод Чингис хааны одон гардуулсан тухай бичвэрийн зарим хэсгийг дахин давтан уншсан (2015.11.15), сонгууль өнгөрөөд нэг хонож байхад “Өнөөдрийн 12 цагийн байдлаар сонгуулийн санал хураалт хангалтгүй байна” (TV-1. 2016.10.20) гэж уншсан зэрэг нь цөм хариуцлагагүйн хар гай мөн байв. Телевиз бол үзэх, сонсох боломжийг давхар олгодог хэрэгсэл. Гэтэл манай сэтгүүлчид дэлгэцэнд гарч байгаа зүйлийг тайлбарлаж цагаа бардаг, сэтгүүлч, нэвтрүүлэгч хоёр нэг өгүүлбэрийг ёс мэт давхардуулан уншдаг дутагдлаас салж чадахгүй байсаар.

Заримдаа хэтэрхий жудаггүй, хүнлэг бус утга агуулгатай юм ярьж, бичдэг нь ихэнхдээ мэдлэг, хариуцлага дутсантай холбоотой байна. “Монголын мэдээ” сувгийн 2016 оны 7 дугаар

сарын 9-ний өдрийн “Цагийн хүрд”-д “Домбаст үрэгдсэн иргэдийн тоо 2015 оны наймдугаар сараас хойш дээд амжилт тогтоолоо” гэхийг сонссон хэн боловч Үндэсний телевизийнхэн бусдын зовлонгоор даажигнадаг болоо шив гэж бодох нь тодорхой. “Монголын мэдээ” сувгийн 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Цагийн хүрд”-ээр “Хэрэв энэ хэвээрээ байвал барилгын салбар шууд зогсолтонд орох боломжтой” гэж ярихыг сонссон хэн ч манай сэтгүүлчид бүтээн байгуулалт зогсоосой гэж хүсдэг юм болов уу гэх биз.

Бусад телевизэд үлгэр үзүүлж, зөв ярьж, бичихийн эталон болж байх учиртай Үндэсний олон нийтийн телевизийг үзэж суухад үнэхээр урам хугармаар алдаа мадаг захас аван тааралддаг. Тус телевиз “Тархины харвалтын дэлхийн өдөр” (“Цагийн хүрд”. 2016.10.25), “Монгол улсын хэмжээнд 119 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байдаг” (“Цагийн хүрд”. 2016.10.25), “Өсвөрийн даамны дэлхийн аварга шалгаруулах тэмцээн” (“Цагийн хүрд”. 2016.11.01), “Халх голын 330 мянган га газрыг нэг шөнийн дотор олгожээ” (“Цагийн хүрд”. 2016.11.01) гэх мэтээр ярьж, бичиж байх юм. Эхний өгүүлэмжид “харвалтын” гэдэг үгийн ард “эсрэг” гэх мэт үг дутсанаас харвалтыг дэмжсэн мэт утга гарч байна. “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр” гэдэг шиг “харвалтын өдөр” байж болохгүй биз дээ. Хоёр дахь өгүүлбэрийг уншсан хүн “Хөөрхий дөө, 119 бэрхшээлтэй байж яаж амьд явдаг юм бол” гэж гайхах нь магад. Үүний оронд “Хөгжлийн бэрхшээлтэй 119 иргэн” гэвэл

маргаангүй болох байж. Гурав дахь өгүүлбэрийг зөв найруулъя гэвэл “Өсвөрийн даамны дэлхийн аварга” биш, “Өсвөрийн даамчдын дэлхийн аварга” гэх ёстой. Сүүлчийн өгүүлбэр эзэн биегүй болжээ. 330 мянган га газрыг олгосон, авсан эзэн байхгүй учир хоосон үг болохоос хэтэрсэнгүй.

Энэ мэт алдаатай үг, өгүүлбэр арилжааны телевизүүдэд бүр ч элбэг үзэгддэг. Телевизорынхоо өмнө суусан үзэгчид “Мөн дүүрэгт хэд хэдэн Засгийн газрын гишүүд амьдардаг юм байна” (“Монгол TV”. 2015.12.14), “Ярилцлагыг маань хүлээн авч ярилцлага өгсөн танд баярлалаа” (“Eagle news”. 2015.12.05), “Насаар нь толгойны өвчинтэй болгох гээгүй л бол хүүхдийнхээ дулаан хувцаслалтанд анхаар” (TV-8. “Толь” мэдээллийн хөтөлбөр), “Европд 3 сая дүрвэгсэд хүрэлцэн иржээ” (TV-10. Мэдээ. 2015.12.26), “Гоолиг бэлхүүс, харвингийн эсрэг тос” (CITI CHANNEL. 2016 01.07), “Манай улс өргөн хэрэглээний барааныхаа 70 хувийг доллар ашиглан гадаадаас авдаг” (TV-8. “Толь” мэдээллийн хөтөлбөр), “Тариа хураалт 102 сая тонноос давлаа” (“Eagle news”. 2015.12.05), “2048 сонгуулийн насны иргэд бүртгэгджээ” (TV-8. “Толь” мэдээллийн хөтөлбөр. 2016.03.02), “Үл хөдлөх хөрөнгийн цагаар Нарны хорооллын 3 дугаар ээлжийг хүргэлээ” (“Eagle news”. 2015.12.18), “Дорго хэмээх хөөрхөн амьтан үдийнхээ унтлагыг хийж байна” (“Соён гэгээрүүлэгч TV”. Ш.Хишигсүрэн. 2015.12.16), “Сэтгүүлч миний зүгээс бодож байхад” (TV-8. “Алаг шаазгай”. 2015.12.17) гэх мэтийг үзэж, сонсоод “Даан ч дээ. Монголын телевизүүд ингэтлээ шарлах гэж дээ”

хэмээн бухимдаж суух нь аргагүй. Бичиг үсэгт сайн тайлагдаагүй хүн телевизэд ажилладаг юм биш биз гэх сэтгэгдэл ч зарим үед төрдөг. “МХЗЭ” гэх товчилсон үгийг “Монголын хүүхэд залуучуудын эвлэл” (NTV телевиз. “Үндэсний мэдээ”. 2016.10.29) гэж уншдаг сэтгүүлч байх юм. Тэгсэн атлаа “ЗЦГ-ын УСОНХХ”, “ОНӨААТҮГ” гэх мэтээр товчлохыг нь яана.

Дордож, доошоо ороход бас хэмжээ хязгаар гэж бий. Тэр хязгаарыг Монголын зарим телевиз аль хэдийнэ гаталчихсан байна. Тод жишээ нь “TV-1” телевизийн нэг сэтгүүлч 2016 оны 9 дүгээр сарын 14-ний мэдээллийн хөтөлбөрөөр “Их Британи дүрвэгсдийн урсгалыг хаах зорилгоор хана босгох болсон тухай тус улсын Доод хэргийн яам мэдээлэв” хэмээн өндөр дуугаар уншиж байсан явдал мөн. Бүхэл бүтэн нэг улсын төрийн яамны нэрийг ингэж бүсэлхийнээс доошоох хэрэг эрхэлдэг мэтээр доромжилно гэдэг өөрөө дордохын туйлд хүрсний гэрч юм.

Мэргэжлийн үүднээс авч үзвэл нийтлэл нэвтрүүлгийн бодлого, цаг үеэ тусгасан байдал, шуурхай чанар, мэдээ материалын үр нөлөө зэрэг үзүүлэлтүүд нэн чухал боловч телевиз үзэгчид тэр бүхнийг тэгтлээ их анзаараад байдаггүй. Харин тэд, илэрхий алдаатай, болхи үг, өгүүлбэрийг соргог мэдэрдэг, тэр нь телевизийг муухай харагдуулдгийг бодууштай. Дээд тал нь 800, доод зах нь 70-80 хүн агуулж чаддаг телевизүүд ядаж ганц хоёр утга зохиолын ажилтантай болж үг, өгүүлбэрийнхээ алдаа мэдгийг шүүтгүүлж, засуулдаг байвал дээр дурдсанчлан үгийн “бөөс”-нд баригдаж, боловс-

ролтой үзэгчдийнхээ доог тохуу болохгүй байхсан даа.

Ашигласан материалын жагсаалт

1. МҮОНТ-ийн “Монголын мэдээ” сувгийн 1915-1916 оны “Цагийн хүрд” нэвтрүүлгүүд.
2. МҮОНТ-ийн “Монголын мэдээ” сувгийн 1916 оны зарим мэдээнүүд.

3. Монголын арилжааны телевизүүдийн 1915, 1916 оны мэдээллийн хөтөлбөрүүд

4. *Норовсүрэн Л., Ариунзаяа Н.* 2009. Телевизийн сэтгүүл зүй. УБ

5. *Норовсүрэн Л.* 2008. Хянан найруулах ухаан. УБ.

6. *Наранжаргал Х.* 2006. Телевизийн сэтгүүл зүй: үндсэн ойлголт, зөвлөмж. УБ.

7. *Ариунзаяа Н.* 2015. Сэтгүүл зүйн онол, түүхийн асуудлууд. УБ.